

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ 2020 ОНЫ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭТЭИ ХАРЬЦУУЛАХАД НИИТ ДҮНГЭЭРЭЭ 70.1 ХУВИАР НЭМЭГДСЭН БАЙНА

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/11-ШТА-НА

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317
Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114
Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор З.Даваадорж Утас: 91890258
Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn
Аудитор С.Гансүх Утас: 95908400
Цахим хаяг: Gansukhsa@audit.gov.mn
Аудитор Г.Ичинхорлоо Утас: 88688168
Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИАР НЭГ НАМ, ЭВСЛЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ АЙМАГТ 491.5 САЯ ТӨГРӨГ, МӨРӨН СУМАНД 153.3 САЯ ТӨГРӨГ, БУСАД СУМДАД ДУНДЖААР 79.4 САЯ ТӨГРӨГ БАЙХААР ТОГТООЛОО.

1.1 Сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэхэд нам, эвслээс гарах зардлын дээд хэмжээг аймагт 211.4 сая төгрөг, Мөрөн суманд 66.2 сая төгрөг, сумдад дунжаар 6.6 сая төгрөг байхаар тогтоолоо.

1.2 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардлыг аймагт 47.7 сая төгрөг, Мөрөн суманд 5.2 сая төгрөг, бусад сумдад дунджаар 1.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

1.3 Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардлыг аймагт 25.0 сая төгрөг, Мөрөн суманд 1.9 сая төгрөг, бусад сумдад дунджаар 1.0 сая төгрөг байхаар тогтоолоо.

1.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардлыг аймагт 23.2 сая төгрөг, Мөрөн суманд 1.4 сая төгрөг, бусад сумдад дунджаар 1.0 сая төгрөг байхаар тогтоолоо.

1.5. Сонгууль эрхэлсэн байгууллагын зардлыг аймагт 133.6 сая төгрөг, сумдад 22.8 сая төгрөг байхаар тогтоолоо.

1.6. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардлыг аймаг, сумдад ижилхэн 27.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

1.7. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардлыг аймаг, сумдад ижилхэн 11.3 сая төгрөг байхаар тогтоолоо.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ЭЭЛЖИТ СОНГУУЛИАР АЙМГИЙН ИТХ-Д НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ДУНДЖААР 58.2 САЯ ТӨГРӨГ, СУМЫН ИТХ-Д НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ДУНДЖААР 20.1 САЯ ТӨГРӨГ БАЙХААР ТОГТООЛОО.

2.1 Сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэхэд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймагт дунджаар 7.3 сая төгрөг, сумдад дунджаар 1.6 сая төгрөг байхаар тогтоолоо.

2.2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардлыг аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 1.3 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 0.4 сая төгрөг байхаар тогтоолоо.

2.3. Нэр дэвшигчээс зарцуулах сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардлыг аймагт дунджаар 0.9 сая төгрөг, сумдад дунджаар 0.3 сая төгрөг байхаар тогтоолоо.

2.4. Сонгууль эрхэлсэн байгууллагын зардлыг аймгийн ИТХ-д нэр дэвшигчийн хувьд дунджаар 21.4 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчийн хувьд дунджаар 13.0 сая төгрөг байхаар тогтоолоо.

2.5. Нэр дэвшигчээс зарцуулах сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардлыг аймагт дунджаар 6.3 сая төгрөг, сумдад дунджаар 2.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

2.6. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардлыг аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 11.3 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 1.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

НАМУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛ

ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ШТС	Шатахуун түгээх станц
УБ	Улаанбаатар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/23

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, МУЕА-ын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газарт хүргүүлж, нийтэд мэдээлсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/162 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов баталсан Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох ажлыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Энэ хуульд нийцүүлэн Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ" гэж заасны дагуу орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс аймаг, суман дахь сонгуулийн тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршино.

Дээрх зорилтын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэх;
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Хөвсгөл аймгийн ИТХ, сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, сумдын ИТХ, Сод Монгол групп, Шунхлай ХХК, Хөвсгөл-НИК, Улаанбаатар принт ХХК, Сэлэнгэ пресс ХХК, Интер прэсс ХХК, Шоо дизайн ХХК, Брэнд Экспо ХХК, Сити дизайн ХХК, Дөл хангай ХХК, Танан тансаг хатгамал, Хөвсгөл ард түмний телевиз, Далай-Ээж телевиз, Сайхан монгол телевизээс авсан мэдээллийг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/52 тушаалаар баталсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлыг тогтоох аргачлал"-ын /цаашид "аргачлал" гэнэ/ дагуу холбогдох байгууллагуудаас аудитад шаардагдах судалгаа баримт, мэдээлэл, гаргуулан авч, ирүүлсэн нотлох зүйлс, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг горим арга зүйг ашиглалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Улс төрийн намын тухай хууль;
- Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/52 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал";
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаал;
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 12 дугаар тогтоол;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлэн, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Г.Ичинхорлоо, С.Гансүх нар 2024 оны 05 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл:

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, Хөвсгөл аймгийн орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын хязгаарлалт:

Орон нутагт сэтгүүл хэвлэдэг байгууллага болон домэйн нэр, хост, контент бэлтгэх, цахим хуудас идэвхжүүлэлт хийх байгууллага байхгүй, сонин хэвлэх байгууллага ганц байдаг, оффсет хэвлэлийн газар байхгүй мөн нам, эвсэл, нэр дэвшигчээс өмнөх сонгуулиар ирүүлсэн сонгуулийн зардлын тайланд сонгогчидтой хийсэн уулзалт, цуглаан, болон бусад үйл ажиллагааны зардлыг дэлгэрэнгүй байдлаар тусгаагүй нь аудитын хязгаарлалт бий болгож байна.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлаас "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль"-ийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр шинэчлэн баталсан байна.

Хөвсгөл аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны А/16, А/17 дугаар тушаалуудаар аймгийн ИТХ-ын сонгуульд нам, эвсэл 495.9 сая төгрөг, нэр дэвшигч тойргоос хамааран 19.8 саяас 74.6 сая төгрөг, сумын ИТХ-ын сонгуульд нам, эвсэл 13.4 саяас 109.8 сая төгрөг, нэр дэвшигч сумын тойргоос хамааран 8.7 саяас 38.6 сая төгрөг байхаар тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн XXVI/15 дугаар тогтоолоор Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тойргийн тоо 37, мандатын тоо 41, хүн амын тоо 136,885 гэж тогтоосон байна.

Сонгуулийн зардлыг тооцоолохдоо Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38-47 дугаар зүйлийг үндэслэл болгосон бөгөөд сонгуулийн сурталчилгааны арга, хэлбэр, сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүн, тойрог, хэсэг, өрхийн тоо, сонгогчийн тоо, сонгуульд ашиглах материалын үнэ, шуудангийн үнэ тариф зэрэг холбогдох мэдээллийн дагуу нарийвчилж тогтоолоо.

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэг нам, эвслээс зарцуулах дараах зардлын дээд хэмжээг аймгийн хэмжээнд болон 23 сум тус бүрээр тогтоолоо. Үүнд:

- Сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэх, сонгогчдод тараах,
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал
- Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал
- Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал
- Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал
- Сонгууль эрхэлсэн байгууллагын цалин хөлс, шатахуун болон бусад зардал
- Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал
- Цахим орчин ашиглах зардал

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар аймгийн ИТХ-д нэр дэвшигчийг Мөрөн сумын 14 баг, бусад 22 сум бүрээр, сумын ИТХ-д нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 23 сумын 129 баг бүрээр тогтоолоо. Үүнд:

- Сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэх зардал

- Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал
- Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал
- Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал
- Нэр дэвшигчийн менежер, шадар туслах, ухуулагчийн цалин, шатахуун болон бусад зардал
- Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал
- Цахим орчин ашиглах зардал

Зардлын дээд хэмжээ тогтооход шаардлагатай мэдээллүүдийг дараах байгууллагуудаас гаргуулан авч, тооцоололд ашигласан. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсээс өрхийн тоог,
- Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс сонгогчийн тоо болон хэсгийн тоог,
- Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан тойргийн тоо, мандатын тоо, хүн амын тоо, нутаг дэвсгэр түүний төв,
- Улаанбаатар хотод хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 3 компанийн үнэ, тариф,
- Хөвсгөл аймагт шуудан хүргэлтийн үйл ажиллагааг “Монгол шуудан” ХК дангаараа гүйцэтгэж байгаа тул тооцоололд тус байгууллагын үнийг /3300 төгрөг/ ашигласан.
- Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй Хөвсгөл аймагт үйл ажиллагаа эрхэлдэг 3 телевизийн үнэ, тариф
- Хөвсгөл аймагт цахим үйлчилгээ эрхэлдэг байгууллага байхгүй учраас УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээний тооцооллыг ашигласан.
- Сонгуулийн ажилтны хөлс, урамшууллын зардлыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолыг баримтлан тооцоолсон.

БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИАР НЭГ НАМ, ЭВСЛЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ АЙМАГТ 491.5 САЯ ТӨГРӨГ, МӨРӨН СУМАНД 153.3 САЯ ТӨГРӨГ, БУСАД СУМДАД ДУНДЖААР 79.4 САЯ ТӨГРӨГ БАЙХААР ТОГТООЛОО.

1.1 Сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэхэд нам, эвслээс гарах зардлын дээд хэмжээг аймагт 211.4 сая төгрөг, Мөрөн суманд 66.2 сая төгрөг, сумдад дунжаар 6.6 сая төгрөг байхаар тогтоолоо.

АНСДИТХСТ хуулийн 40 дүгээр зүйлийн холбогдох зохицуулалтыг шалгуур болгон, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13.1, 13.3, 36 дугаар зүйлийг тус тус харгалзан нам эвслийн сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэх хуудасны тоог дараах байдлаар тооцсон.

№	Хуулийн 40.1 дэх заалт	Хуулийн 40.8 дахь заалт	А4 бичгийн цаасны нүүрээр тооцсон хуудасны тоо
1	Гурван хэвлэлийн хуудас сонин		24 нүүр
2	Гурван хэвлэлийн хуудас сэтгүүл	А4 бичгийн цаасны 8 нүүр	24 нүүр
3	Нэг хэвлэлийн хуудас ухуулах хуудас		8 нүүр

Сонин хэвлүүлэх зардлын тооцоолол

Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сонин хэвлэлийн газар ганц байдаг тул Үндэсний аудитын газрын цуглуулсан сонин хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 46 төгрөг гэж тооцоолсон. Үүнд:

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Сонины нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	16	634	39.625

2	Интер пресс	16	710	44.375
3	Улаанбаатар принт	16	860	53.75
Нийт үнэ				137.75
Дундаж үнэ				46

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох” аудитын тайлан

Сонин хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо. Үүнд:
(Сонин хэвлүүлэх зардал=24 нүүр*дундаж үнэ*өрхийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу сонин хэвлүүлэх зардлыг тооцож аймагт 44.3 сая төгрөг, Мөрөн суманд 14.0 сая төгрөг, бусад сумдад 1.4 сая төгрөгөөр тогтоов.

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 1-ээс үзнэ үү/

Сэтгүүл хэвлүүлэх зардлын тооцоолол

Хөвсгөл аймагт сэтгүүл хэвлэлийн газар байхгүй учраас Үндэсний аудитын газрын цуглуулсан сэтгүүл хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 65 төгрөг гэж тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Сэтгүүлийн нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	16	770	48.125
2	Интер пресс	16	1010	63.125
3	Улаанбаатар принт	16	1320	82.5
Нийт үнэ				193.75
Дундаж үнэ				65.0

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох” аудитын тайлан

Сэтгүүл хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо. Үүнд:

Хэвлэлийн А4 бичгийн цаасны 24 нүүрийг сэтгүүл хэвлэлийн гурван компанийн үнийн дунджаар үржүүлж, түүнийг өрхийн тоогоор үржүүлсэн дүнгээр сэтгүүл хэвлүүлэх зардлыг тооцоолсон.

(Сэтгүүл хэвлүүлэх зардал=24 нүүр*дундаж үнэ*өрхийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу сэтгүүл хэвлүүлэх зардлыг тооцож аймагт 62.7 сая төгрөг, Мөрөн суманд 19.8 сая төгрөг, бусад сумдад 1.9 сая төгрөгөөр тогтоов.

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 2-оос үзнэ үү./

Ухуулах хуудас хэвлүүлэх зардлын тооцоолол.

Хөвсгөл аймагт оффсет хэвлэлийн газар байхгүй учраас Үндэсний аудитын газрын цуглуулсан хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 92.5 төгрөг гэж тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Ухуулах хуудасны нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	8	668	83.5
2	Интер пресс	8	690	86.25
3	Улаанбаатар принт	8	860	107.5
				277.25
Дундаж үнэ				92.5

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох” аудитын тайлан

Ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо. Үүнд:

Хэсэгт байршуулах ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцохдоо нэг хэвлэлийн хуудас буюу А4 цаасны 8 нүүрийг хэвлэлийн гурваас доошгүй компанийн үнийн дунджаар үржүүлж, түүнийг хэсгийн тоо болон нэг хэсгийн хороонд тараах ухуулах хуудасны зөвшөөрөгдөх хэмжээ буюу 20 ширхгээр үржүүлнэ.

(Ухуулах хуудас хэвлүүлэх зардал = 8 нүүр * дундаж үнэ * сонгогчийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу Ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцож аймагт 64.9 сая төгрөг, Мөрөн суманд 20.2 сая төгрөг, бусад сумдад 2.0 сая төгрөгөөр тогтоов.

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 3-аас үзнэ үү./

Хэсэгт байршуулах ухуулах хуудасны зардлын дээд хэмжээг аймагт 1.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

Хөвсгөл аймагт оффсет хэвлэлийн газар байхгүй учраас Үндэсний аудитын газрын цуглуулсан хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 92.5 төгрөг гэж тооцоолсон. Үүнд:

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Ухуулах хуудасны нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	8	668	83.5
2	Интер пресс	8	690	86.25
3	Улаанбаатар принт	8	860	107.5
				277.25
				92.5

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох" аудитын тайлан

Хэсэгт байршуулах ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо.

Хэвлэлийн А4 бичгийн цаасны 8 нүүрийг хэвлэлийн гурван компанийн үнийн дунджаар үржүүлж, түүнийг сонгогчийн тоогоор үржүүлсэн дүнгээр ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцоолсон.

(Ухуулах хуудас хэвлүүлэх зардал /хэсэг/ = 8 нүүр * дундаж үнэ * 20 ш * хэсгийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу хэсэгт байршуулах ухуулах хуудасны хэвлүүлэх зардлыг тооцож аймагт 1.9 сая төгрөг, Мөрөн суманд 0.2 сая төгрөг, бусад сумдад 0.08 сая төгрөгөөр тогтоов.

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 4-өөс үзнэ үү./

Сонгуулийн сурталчилгааны материал тараах зардлын тооцоолол.

АНСДИТХСТ хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т заасны дагуу нам эвсэл нь 24 нүүр сонин, 24 нүүр сэтгүүл, 8 нүүр ухуулах хуудас сонгогчдод тараах эрхтэй бөгөөд нийт 56 нүүр сурталчилгааны материалыг айл өрхөд хүргүүлэхээр тооцоолсон.

Шуудан хүргэлтийн зардлыг тооцохдоо сурталчилгааны материалын 1 хуудас а4 цаасны жинг 5гр-аар тооцож, түүнийг нийт сурталчилгааны материалын тоо, шуудан хүргэлтийн дундаж үнээр үржүүлсэн.

(Шуудан хүргэлтийн зардал = Сурталчилгааны материалын жин * шуудан хүргэлтийн үнэ)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу Сонгуулийн сурталчилгааны материал тараах зардлыг тооцож аймагт 37.5 сая төгрөг, Мөрөн суманд 11.7 сая төгрөг, бусад сумдад 1.2 сая төгрөгөөр тогтоов. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 5-аас үзнэ үү/

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэг нам, эвслээс зарцуулах сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардлын дээд хэмжээг 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулбал аймагт 27.7 хувиар бууруулж 211.4 сая

төгрөг, Мөрөн суманд 26.1 хувиар бууруулж 66.2 сая төгрөг, бусад сумдад 28.4 хувиар бууруулж дунджаар 6.6 сая төгрөг байхаар тогтоолоо.

1.2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардлыг аймагт 47.7 сая төгрөг, Мөрөн суманд 5.2 сая төгрөг, бусад сумдад дунджаар 1.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байршуулах зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо.

Гудамж талбайд байршуулах зурагт самбар хэвлэх үнийн судалгааг Хөвсгөл аймагт үйл ажиллагаа эрхэлдэг 2 хэвлэлийн байгууллага, Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг 2 байгууллага, нийт 4 байгууллагын үнийн саналыг ашиглан дундаж үнийг дараах байдлаар тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	1мк хулдаасан хэвлэлийн үнэ /төг/	Самбарын модон рам /төг/	Самбар хэвлэх нийт үнэ /төг/	Байршил
1	Брэнд экспо ХХК	15000	22000	37000	Хөвсгөл аймагт байрладаг УБ-т байрладаг
2	Шоо дизайн ХХК	15000	22000	37000	
3	Сити дизайн ХХК	15000	22000	37000	
4	Дөлхангай ХХК	15000	22000	37000	
Нийт үнэ				148000	
Дундаж үнэ				37000	

Зурагт самбар байрлуулах зардлыг тооцоололд сонгуулийн хэсгийн тоо, АНСДИТХСТ хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-т заасан зурагт самбарын зөвшөөрөгдөх хэмжээ болох 10 ширхэг, хэвлэлийн байгууллагуудаас ирүүлсэн дундаж үнийг ашигласан.

(Зурагт самбар байрлуулах зардал= Дундаж үнэ*хэсгийн тоо*зөвшөөрөгдөх зурагт самбарын тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардлыг тооцож аймагт 47.7 сая төгрөг, Мөрөн суманд 5.2 сая төгрөг, бусад сумдад 1.9 сая төгрөгөөр тогтоов. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 6-аас үзнэ үү/ 2020 оны сонгуулиар зурагт самбар байршуулах зардлыг тооцоолоогүй байсан.

1.3. Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардлыг аймагт 25.0 сая төгрөг, Мөрөн суманд 1.9 төгрөг, бусад сумдад дунджаар 1.0 сая төгрөг байхаар тогтоолоо.

Намын далбаа хэвлэх үнийн судалгааг Хөвсгөл аймагт үйл ажиллагаа эрхэлдэг 1 хэвлэлийн байгууллага, Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг 3 байгууллага, нийт 4 байгууллагын үнийн саналыг ашиглан дундаж үнийг дараах байдлаар тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	1мк хэвлэлийн үнэ /төг/	Байршил
1	Танан тансаг хатгамал ХХК	15000	УБ-д байрладаг
2	Шоо дизайн ХХК	15000	Хөвсгөл аймагт байрладаг
3	Сити дизайн ХХК	15000	УБ-д байрладаг
4	Дөлхангай ХХК	15000	
Нийт үнэ		60000	
Дундаж үнэ		15000	

Намын далбааг гудамж талбайд байршуулах зардлын тооцоололд тээврийн хэрэгсэл, ухуулах байр, сонгогчидтой хийх уулзалт хурал цуглаанд ашиглах намын далбааны нийлбэр, хэвлэлийн байгууллагаас ирүүлсэн үнийн дунджийг ашигласан.

(Намын далбаа хэвлүүлэх зардал=(A+B+C)*дундаж үнэ)

МҮЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу нэг нам, эвслээс зарцуулах “Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах” зардлын дээд хэмжээг 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулбал аймагт 3.5 хувиар бууруулж 25.0 сая төгрөг, Мөрөн суманд 6.7 хувиар өсгөж 1.9 сая төгрөг, бусад сумдад 3.5 хувиар бууруулж дунджаар 1.0 сая төгрөг байхаар тогтоолоо. /Дэлгэрэнгүйг тооцооллыг хавсралт 7-оос үзнэ үү/

1.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардлыг аймагт 23.2 сая төгрөг, Мөрөн суманд 1.4 сая төгрөг, бусад сумдад дунджаар 1.0 сая төгрөг байхаар тогтоолоо.

МҮЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу 2020 оны сонгуулиар нам, эвслийн зардлын тайланд тусгасан сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардлын дунджийг тооцоололд ашиглах ёстой.

Гэвч орон нутгийн 2020 оны сонгуулиар нам эвслүүд нь уулзалт, хурал цуглааны зардлыг салгаж тайлагнаагүй байна. Иймээс 2020 онд тухайн зардлын дээд хэмжээг тогтооход ашигласан дүнг сүүлийн 3 жилийн инфляцын өсөлттэй уялдуулан тооцооллоо.

(Уулзалт хурал цуглаан хийх зардал=Өмнөх сонгуулийн зардлын дундаж дүн*Инфляцын өсөлт 3 жилээр)

Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуулиар тогтоосон зардлын дээд хэмжээг сүүлийн 3 жилийн инфляц болох 36.3 хувиар нэмэгдүүлж аймагт 23.2 сая төгрөг, Мөрөн суманд 1.4 сая төгрөг, бусад сумдад дунджаар 1.0 сая төгрөг байхаар тогтоолоо. /Дэлгэрэнгүйг тооцооллыг хавсралт 8-аас үзнэ үү./

1.5. Сонгууль эрхэлсэн байгууллагын зардлыг аймагт 133.6 сая төгрөг, сумдад 22.8 сая төгрөг байхаар тогтоолоо.

Нам, эвслээс зарцуулах хөлс, урамшууллын зардлын тооцоолол.

Нам, эвслийг төлөөлөн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны хөлс, урамшууллын зардлыг АНСДИТХСТ хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах 20 хүртэл, аймаг, дүүрэгт 50 хүртэл, сум, хороонд 20 хүртэл ажилтантай байж болно.” гэж заасныг үндэслэн нам, эвслийг төлөөлөн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий ажилтны тоо, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /ХХДХ/-г харгалзан дараах байдлаар тооцсон.

А. Аймаг дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтан=ХХДХ*50

Б. Сум, хорооны хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтан=ХХДХ/2*20

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэг нам, эвслээс зарцуулах “Сонгуулийн ажилтны ажлын хөлс, урамшууллын” зардлын дээд хэмжээг аймагт 33.0 сая төгрөг, сумдад 0.7 сая төгрөг байхаар тогтоосон нь 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулахад 57.1 хувиар өссөн байна. Энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна. /Дэлгэрэнгүйг тооцооллыг хавсралт 9-өөс үзнэ үү./

Нам, эвслээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардлын тооцоолол.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийн тойрогт нам, эвслээс зарцуулах шатахууны үнийн саналыг 3 шатахуун түгээх станцаас авч тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	ШТС	Шатахууны үнэ /төг/	Тайлбар
1	НИК	2740	

2	Шунхлай	2590	Сумдад байрладаг штс	Харин	Мөрөн
3	Сод Монгол групп	2590	үнийн хамгийн их болон		сумын
	Нийт үнэ	7920	хамгийн бага үнийн	шатахууны үнийг	
			дунжаар тооцов.	2590 төгрөгөөр	
	Дундаж үнэ	2640		тооцоолсон.	

Аргачлалын дагуу хамгийн ихдээ орон нутагт 80км/цаг хурдтайгаар өдөрт ажлын 8 цагаар, явна гэж үзээд дараах байдлаар өдөрт зарцуулах шатахууныг дараах байдлаар тооцоолсон.

1 өдөрт зарцуулах шатахууны хэмжээ:

100 км-т	15.2 л шатахуун зарцуулна	Зам тээврийн хөгжлийн сайдын 390 дугаар тушаалаар баталсан жишиг нормыг баримтлав.
640 км-т	97.28 л	Өдөрт 80 км/цаг хурдтай 8 цаг /ажлын цаг/ явахад 640 км зам туулна гэж тооцоолсон.

Нам эвслийн ашиглах авто машины марк, түүний 100 км-т зарцуулах шатахууны хэмжээг Зам тээврийн хөгжлийн сайдын 2019.12.30-ны өдрийн “Жишиг норм батлах тухай” 390 дүгээр тушаалын 1 болон 3-р хавсралтыг харгалзан тооцсон.

(Тээврийн хэрэгслийн зардал=Шатахууны үнийн дундаж*1 өдөрт зарцуулах шатахууны хэмжээ*14 хоног*тээврийн хэрэгслийн тоо /1 ширхэг/)

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэг нам, эвслээс зарцуулах “Тээврийн хэрэгслийн” зардлын дээд хэмжээг аймагт 82.6 сая төгрөг, сумдад 3.6 сая төгрөг байхаар тогтоосон нь 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулахад 132.8 хувиар өссөн байна. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 10-аас үзнэ үү/

Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардлын тооцоолол.

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардлыг 2024 оны ээлжит сонгуулийн нийт тооцоолсон зардлын 10 хувь байхаар тооцоолов. (Бусад зардал=Сонгуулийн нийт зардал*Бусад зардлын хувь 10%)

/Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардлыг аймаг, сум тус бүрээр тооцоолсон тооцооллыг зардлын дээд хэмжээ тооцоолсон дэлгэрэнгүй хүснэгтээс үзнэ үү./

1.6. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардлыг аймаг, сумдад ижилхэн 27.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

Орон нутгийн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчид нь өөрийн дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр бусад арга хэмжээгээ радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагаар дамжуулан явуулдаг тул холбогдох зардлыг аргачлалын дагуу тооцсон болно.

Эх бэлтгэх зардлын тооцоолол.

Харилцаа холбооны зохицуулах хороонд сонгуулийн сурталчилгаа явуулахаар бүртгүүлсэн телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлдэг 3 байгууллагын үнийн саналыг авч дараах байдлаар тогтоолоо.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	1 минутын эх бэлтгэх үнэ /төг/	1 минутыг нэвтрүүлэх үнэ /төг/
1	Хөвсгөл ТВ	130,000.0	130,000.0
2	Далай-Ээж ТВ	60,000.0	50,000.0
3	Сайхан Монгол ТВ /Орхон, Булган, Хөвсгөл/	67,000.0	10,000.0
	Нийт үнэ	257,000.0	190,000.0
	1 минутын дундаж үнэ	85,666.7	63,333.3
	Сурталчилгаа нэвтрүүлэх хугацаа	15 мин	15 мин
	15 минутын дундаж үнэ	1,285,000.0	1,900,000.0

АНСДИТХСТ хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д "Сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно" гэж заасныг үндэслэн эх бэлтгэх зардлыг тооцоолсон. (Эх бэлтгэх зардал=Дундаж үнэ*нийт тойргийн тоо*15)

Нэвтрүүлгийн зардлын тооцоолол.

Аргачлалын дагуу нэвтрүүлэх зардлын хэмжээг тогтоохдоо дундаж үнэ, нам эвсэлд ногдох хугацаа/15 мин/, сонгуулийн сурталчилгааны хоногийн үржвэрийг телевизийн байгууллагын тоогоор үржүүлж тооцоолсон.

(Нэвтрүүлгийн зардал=(Дундаж үнэ*нам эвсэлд ногдох минут*14 хоног)*радио төв байгууллагын тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу нэг нам, эвслээс зарцуулах Радио, телевиз ашиглах зардлын дээд хэмжээг тооцоолж аймаг, сум тус 27.9 сая төгрөг байхаар тогтоов. /Дэлгэрэнгүйг тооцооллыг хавсралт 11-ээс үзнэ үү/

1.7. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардлыг аймаг, сумдад ижилхэн 11.3 сая төгрөг байхаар тогтоолоо.

Хөвсгөл аймагт цахим орчны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байхгүй тул Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын үнэ, тарифыг ашиглан аргачлалын дагуу тооцоолсон.

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу нэг нам, эвслээс зарцуулах цахим орчинд ажиллах зардлын дээд хэмжээг тооцоолж аймаг, сум тус 11.3 сая төгрөг байхаар тогтоов. /Дэлгэрэнгүйг тооцооллыг хавсралт 12-оос үзнэ үү/

Радио телевиз, цахим орчин ашиглах зардлыг 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулахад аймагт 20.6 хувиар, сумдад 2500 орчим хувиар өссөн байна. Энэ нь сонгуулийн сурталчилгаанд радио телевиз болон цахим орчин ашиглах хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ЭЭЛЖИТ СОНГУУЛИАР АЙМГИЙН ИТХ-Д НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ДУНДЖААР 58.2 САЯ ТӨГРӨГ, СУМЫН ИТХ-Д НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ДУНДЖААР 20.1 САЯ ТӨГРӨГ БАЙХААР ТОГТООЛОО.

2.1 Сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэхэд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймагт дунджаар 7.3 сая төгрөг, сумдад дунджаар 1.6 сая төгрөг байхаар тогтоолоо.

АНСДИТХСТ хуулийн 40 дүгээр зүйлийн холбогдох зохицуулалтыг шалгуур болгон, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13.1, 13.3, 36 дугаар зүйлийг тус тус харгалзан нам эвслийн сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэх хуудасны тоог дараах байдлаар тооцсон.

№	Хуулийн 40.1 дэх заалт	Хуулийн 40.8 дахь заалт	А4 бичгийн цаасны нүүрээр тооцсон хуудасны тоо
1	Гурван хэвлэлийн хуудас сонин		24 нүүр
2	Гурван хэвлэлийн хуудас сэтгүүл	А4 бичгийн цаасны 8 нүүр	24 нүүр
3	Нэг хэвлэлийн хуудас ухуулах хуудас		8 нүүр

Сонин хэвлүүлэх зардлын тооцоолол

Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сонин хэвлэлийн газар ганц байдаг тул Үндэсний аудитын газрын цуглуулсан сонин хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 46 төгрөг гэж тооцоолсон. Үүнд:

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Сонины нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	16	634	39.625
2	Интер пресс	16	710	44.375
3	Улаанбаатар принт	16	860	53.75
Нийт үнэ				137.75
Дундаж үнэ				46

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох" аудитын тайлан

Сонин хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо. Үүнд:
(Сонин хэвлүүлэх зардал=24 нүүр*дундаж үнэ*өрхийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу сонин хэвлүүлэх зардлыг тооцож аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс 1.2 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс 0.3 сая төгрөгөөр тогтоов.

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 13а,б-аас үзнэ үү/

Сэтгүүл хэвлүүлэх зардлын тооцоолол

Хөвсгөл аймагт сэтгүүл хэвлэлийн газар байхгүй учраас Үндэсний аудитын газрын цуглуулсан сэтгүүл хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 65 төгрөг гэж тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Сэтгүүлийн нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	16	770	48.125
2	Интер пресс	16	1010	63.125
3	Улаанбаатар принт	16	1320	82.5
Нийт үнэ				193.75
Дундаж үнэ				65.0

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох" аудитын тайлан

Сэтгүүл хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо. Үүнд:
Хэвлэлийн А4 бичгийн цаасны 24 нүүрийг сэтгүүл хэвлэлийн гурван компанийн үнийн дунджаар үржүүлж, түүнийг өрхийн тоогоор үржүүлсэн дүнгээр сэтгүүл хэвлүүлэх зардлыг тооцоолсон.

(Сэтгүүл хэвлүүлэх зардал=24 нүүр*дундаж үнэ*өрхийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу сэтгүүл хэвлүүлэх зардлыг тооцож аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс 1.7 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс 0.5 сая төгрөгөөр тогтоов. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 14а,б-ээс үзнэ үү/

Ухуулах хуудас хэвлүүлэх зардлын тооцоолол.

Хөвсгөл аймагт оффсет хэвлэлийн газар байхгүй учраас Үндэсний аудитын газрын цуглуулсан хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 92.5 төгрөг гэж тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Ухуулах хуудасны нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	8	668	83.5
2	Интер пресс	8	690	86.25
3	Улаанбаатар принт	8	860	107.5
				277.25
Дундаж үнэ				92.5

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох" аудитын тайлан

Ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо. Үүнд:

Хэсэгт байршуулах ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцохдоо нэг хэвлэлийн хуудас буюу А4 цаасны 8 нүүрийг хэвлэлийн гурваас доошгүй компанийн үнийн дунджаар үржүүлж, түүнийг хэсгийн тоо болон нэг хэсгийн хороонд тараах ухуулах хуудасны зөвшөөрөгдөх хэмжээ буюу 20 ширхгээр үржүүлнэ.

(Ухуулах хуудас хэвлүүлэх зардал = 8 нүүр * дундаж үнэ * сонгогчийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцож аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс 1.5 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс 0.5 сая төгрөгөөр тогтоов. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 15а,б-ээс үзнэ үү/

Хэсэгт байршуулах ухуулах хуудасны зардлын дээд хэмжээг аймагт 1.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

Хөвсгөл аймагт оффсет хэвлэлийн газар байхгүй учраас Үндэсний аудитын газрын цуглуулсан хэвлэлийн газрын дараах 3 байгууллагын үнийн саналыг авч дундаж үнийг 92.5 төгрөг гэж тооцоолсон. Үүнд:

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	Ухуулах хуудасны нүүр	Үнэ	Нэг нүүр хэвлэх үнэ /төг/
1	Сэлэнгэ пресс ХХК	8	668	83.5
2	Интер пресс	8	690	86.25
3	Улаанбаатар принт	8	860	107.5
				277.25
				92.5

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох" аудитын тайлан

Хэсэгт байршуулах ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо.

Хэвлэлийн А4 бичгийн цаасны 8 нүүрийг хэвлэлийн гурван компанийн үнийн дунджаар үржүүлж, түүнийг сонгогчийн тоогоор үржүүлсэн дүнгээр ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцоолсон.

(Ухуулах хуудас хэвлүүлэх зардал /хэсэг/ = 8 нүүр * дундаж үнэ * 20 ш * хэсгийн тоо)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу хэсэгт байршуулах ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцож аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс 1.9 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс 0.1 сая төгрөгөөр тогтоов. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 16а,б-ээс үзнэ үү/

Сонгуулийн сурталчилгааны материал тараах зардлын тооцоолол.

АНСДИТХСТ хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т заасны дагуу нам эвсэл нь 24 нүүр сонин, 24 нүүр сэтгүүл, 8 нүүр ухуулах хуудас сонгогчдод тараах эрхтэй бөгөөд нийт 56 нүүр сурталчилгааны материалыг айл өрхөд хүргүүлэхээр тооцоолсон.

Шуудан хүргэлтийн зардлыг тооцохдоо сурталчилгааны материалын 1 хуудас А4 цаасны жинг 5гр-аар тооцож, түүнийг нийт сурталчилгааны материалын тоо, шуудан хүргэлтийн дундаж үнээр үржүүлсэн.

(Шуудан хүргэлтийн зардал = Сурталчилгааны материалын жин * шуудан хүргэлтийн үнэ)

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу хэсэгт байршуулах ухуулах хуудас хэвлүүлэх зардлыг тооцож аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс 1.0 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс 0.3 сая төгрөгөөр тогтоов. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 17а,б-ээс үзнэ үү/

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэр дэвшигчээс зарцуулах "Сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах" зардлын дээд хэмжээг 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулбал аймагт 54.3 хувиар бууруулж дунджаар 7.3 сая төгрөг, сумдад 60 хувиар бууруулж дунджаар 1.6 сая төгрөг байхаар тогтоолоо.

2.2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардлыг аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 1.3 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 0.4 сая төгрөг байхаар тогтоолоо.

Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байршуулах зардлыг дараах аргачлалын дагуу тооцооллоо.

Гудамж талбайд байршуулах зурагт самбар хэвлэх үнийн судалгааг Хөвсгөл аймагт үйл ажиллагаа эрхэлдэг 2 хэвлэлийн байгууллага, Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг 2 байгууллага, нийт 4 байгууллагын үнийн саналыг ашиглан дундаж үнийг дараах байдлаар тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	1мк хулдаасан хэвлэлийн үнэ /төг/	Самбарын модон рам /төг/	Самбар хэвлэх нийт үнэ /төг/	Байршил
1	Брэнд экспо ХХК	15000	22000	37000	Хөвсгөл аймагт байрладаг
2	Шоо дизайн ХХК	15000	22000	37000	УБ-т байрладаг
3	Сити дизайн ХХК	15000	22000	37000	
4	Дөлхангай ХХК	15000	22000	37000	
Нийт үнэ				148000	
Дундаж үнэ				37000	

Зурагт самбар байрлуулах зардлыг тооцоололд сонгуулийн хэсгийн тоо, АНСДИТХСТ хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-т заасан зурагт самбарын зөвшөөрөгдөх хэмжээ болох 10 ширхэг, хэвлэлийн байгууллагуудаас ирүүлсэн дундаж үнийг ашигласан.

(Зурагт самбар байрлуулах зардал= Дундаж үнэ*хэсгийн тоо*зөвшөөрөгдөх зурагт самбарын тоо)

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нийтийн эзэмшлийн гудамж талбайд зурагт самбар байрлуулах зардлын дээд хэмжээг аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 1.3 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 0.4 сая төгрөг байхаар тогтоолоо. Энэ нь 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулахад 85 орчим хувиар өссөн нь үнийн өсөлттэй холбоотой байна.

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 18а,б-ээс үзнэ үү/

2.3. Нэр дэвшигчээс зарцуулах сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардлыг аймагт дунджаар 0.9 сая төгрөг, сумдад дунджаар 0.3 сая төгрөг байхаар тогтоолоо.

Аргачлалын дагуу өмнөх сонгуулиар нам, эвслийн зардлын тайланд тусгасан сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардлын дунджийг тооцоололд ашиглах ёстой. Гэвч орон нутгийн 2020 оны сонгуулиар нам эвслүүд нь уулзалт, хурал цуглааны зардлыг салгаж тайлагнаагүй байна. Иймээс 2020 онд тухайн зардлын дээд хэмжээг тогтооход ашигласан дүнг сүүлийн 3 жилийн инфляцын өсөлттэй уялдуулан тооцооллоо.

(Уулзалт хурал цуглаан хийх зардал=Өмнөх сонгуулийн зардлын дундаж дүн*Инфляцын өсөлт 3 жилээр)

Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуулиар тогтоосон зардлын дээд хэмжээг сүүлийн 3 жилийн инфляц болох 36.3 хувиар нэмэгдүүлж аймагт 0.9 сая төгрөг, сумдад дунджаар 0.3 сая төгрөг байхаар тогтоолоо. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 20а,б-ээс үзнэ үү/

2.4. Сонгууль эрхэлсэн байгууллагын зардлыг аймгийн ИТХ-д нэр дэвшигчийн хувьд дунджаар 21.4 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчийн хувьд дунджаар 13.0 сая төгрөг байхаар тогтоолоо.

Ухуулах байрны түрээсийн зардлын тооцоолол.

АНСТИТХСТ хуулийн 44.3 дахь хэсэгт заасны дагуу ухуулах байрыг ажиллуулах хугацаа нь сонгуулийн сурталчилгаа хийх хугацаатай ижил ба 14 хоног ажиллуулахаар тооцсон.

(Ухуулах байрны түрээсийн зардал= Ухуулах байрны тоо*түрээсийн зардал 14 хоногоор)

А. Ухуулах байрны тоог хуулийн 13.3-т үндэслэн тооцсон.

Б. Байрны түрээсийг зах зээлийн үнэ ханшийг харгалзан дараах байдлаар тооцсон бөгөөд Мөрөн суманд 2 дахин нэмэгдүүлж тооцсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	Хэвлэлийн байгууллагын нэр	1 сарын түрээсийн үнэ /төг/	14 хоногийн түрээс /төг/
1	Ахмадын ордон /А бүс/	340,000.0	170,000.0
2	Баянцагаан /А бүс/	500,000.0	250,000.0
	Нийт үнэ	840,000.0	420,000.0
	Дундаж үнэ	420,000.0	210,000.0

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 19а,б-ээс үзнэ үү./

Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардлын тооцоолол.

Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийн менежер, шадар туслагчийн хөлс, урамшууллын зардлыг АНСТИХСТ хуулийн 36 дугар зүйлийн 36.3-т “Нэр дэвшигч өөрийн итгэмжлэл олгосон нэг менежер, баг тус бүрд нэг, аймгийн төвийн баг болон хороо тус бүрд хоёр шадар туслагч, 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болно” гэж заасны дагуу нэр дэвшигчид ажиллах менежер, шадар туслагч, ухуулагчийн тоо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /ХХДХ/-г харгалзан тогтоолоо.

А. Менежерийн хөлс=ХХДХ*2 дахин

Б. Шадар туслагчийн хөлс=шадар туслагчийн тоо*ХХДХ

В. Ухуулагчийн хөлс=ХХДХ/2*Ухуулагчийн тоо

Хөлс, урамшууллын нийт зардал=менежерийн хөлс+шадар туслагчийн хөлс+ухуулагчийн хөлс

МУЕА-ы 2020 оны А/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу “Хөлс, урамшууллын” зардлын дээд хэмжээг аймагт дунджаар 7.3 сая төгрөг, сумдад дунджаар 3.2 сая төгрөг байхаар тогтоосон нь 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулахад 57.1 хувиар өссөн байна. Энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 21а,б-ээс үзнэ үү/

Нам, эвслээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардлын тооцоолол.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийн тойрогт нам, эвслээс зарцуулах шатахууны үнийн саналыг 3 шатахуун түгээх станцаас авч тооцоолсон.

Дундаж үнийн тооцоолол:

№	ШТС	Шатахууны үнэ /төг/	Тайлбар	Харин	Мөрөн
1	НИК	2740	Сумдад байрладаг штс		сумын
2	Шунхлай	2590	үнийн хамгийн их болон		
3	Сод Монгол групп	2590	хамгийн бага үнийн		
	Нийт үнэ	7920	дунжаар тооцов.	2590	төгрөгөөр тооцоолсон.
	Дундаж үнэ	2640			

Аргачлалын дагуу хамгийн ихдээ орон нутагт 80км/цаг хурдтайгаар өдөрт ажлын 8 цагаар, явна гэж үзээд дараах байдлаар өдөрт зарцуулах шатахууныг дараах байдлаар тооцоолсон.

1 өдөрт зарцуулах шатахууны хэмжээ:

100 км-т	15.2 л шатахуун зарцуулна	Зам тээврийн хөгжлийн сайдын 390 дугаар тушаалаар баталсан жишиг нормыг баримтлав.
----------	---------------------------	--

640 км-т

97.28 л

Өдөрт 80 км/цаг хурдтай 8 цаг /ажлын цаг/ явахад 640 км зам туулна гэж тооцоолсон.

Нам эвслийн ашиглах авто машины марк, түүний 100 км-т зарцуулах шатахууны хэмжээг Зам тээврийн хөгжлийн сайдын 2019.12.30-ны өдрийн "Жишиг норм батлах тухай" 390 дүгээр тушаалын 1 болон 3-р хавсралтыг харгалзан тооцсон.

(Тээврийн хэрэгслийн зардал=Шатахууны үнийн дундаж*1 өдөрт зарцуулах шатахууны хэмжээ*14 хоног*тээврийн хэрэгслийн тоо /2 ширхэг/)

МУЕА-ы 2020 оны A/52 дугаар тушаалаар тогтоосон аргачлалын дагуу нэг нэр дэвшигчээс зарцуулах "Тээврийн хэрэгслийн" зардлын дээд хэмжээг аймаг, сумдад ижил 7.1 сая төгрөг байхаар тогтоосон нь 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулахад 7.6 хувиар өссөн байна. Энэ нь шатахууны үнийн өсөлттэй холбоотой байна.

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 22а,б-ээс үзнэ үү/

Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардлын тооцоолол.

Аргачлалын дагуу сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардлыг 2024 оны ээлжит сонгуулийн нийт тооцоолсон зардлын 10 хувь байхаар тооцоолов.

(Бусад зардал=Сонгуулийн нийт зардал*Бусад зардлын хувь 10%)

/Дэлгэрэнгүй тооцооллыг зардлын дээд хэмжээ тооцоолсон дэлгэрэнгүй хүснэгтээс үзнэ үү./

2.5. Нэр дэвшигчээс зарцуулах сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардлыг аймагт дунджаар 6.3 сая төгрөг, сумдад дунджаар 2.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

Орон нутгийн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчид нь өөрийн дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр бусад арга хэмжээгээ радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагаар дамжуулан явуулдаг тул холбогдох зардлыг аргачлалын дагуу тооцсон болно.

Нэвтрүүлгийн зардлын тооцоолол.

Аргачлалын дагуу нэвтрүүлэх зардлын хэмжээг тогтоохдоо дундаж үнэ, нам эвсэлд ногдох хугацаа /15 мин/, сонгуулийн сурталчилгааны хоногийн үржвэрийг телевизийн байгууллагын тоогоор үржүүлж тооцоолсон.

(Нэвтрүүлгийн зардал=(Дундаж үнэ*нам эвсэлд ногдох минут*14 хоног)*радио тв байгууллагын тоо)

/Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт 23а,б-ээс үзнэ үү/

2.6. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардлыг аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 11.3 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс дунджаар 1.9 сая төгрөг байхаар тогтоолоо.

Хөвсгөл аймагт цахим орчны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байхгүй тул Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын үнэ, тарифыг ашиглан аргачлалын дагуу тооцоолсон.

/Цахим орчин ашиглах зардлыг аймаг, сум тус бүрээр тооцоолсон тооцооллыг хавсралт 24а,б-ээс үзнэ үү/

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэр дэвшигчээс зарцуулах "Радио телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг болон цахим орчин ашиглах" зардлын дээд хэмжээг аймагт дунджаар 17.6 сая төгрөг, сумдад дунджаар 4.8 сая төгрөг байхаар тогтоосон нь 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээтэй харьцуулахад материаллаг хэмжээгээр өссөн байна. Энэ нь сонгуулийн сурталчилгаанд радио телевиз болон цахим орчин ашиглах хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймагт 491.5 сая төгрөг, Мөрөн суманд 153.3 сая төгрөг, бусад сумдад дунджаар 79.4 сая төгрөг байхаар тогтоолоо.
2. Орон нутгийн ээлжит сонгуулиар аймгийн ИТХ-д нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг дунджаар 58.2 сая төгрөг, сумын ИТХ-д нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг дунджаар 20.1 сая төгрөг байхаар тогтоолоо.
3. Орон нутгийн 2024 оны сонгуулийн зардлын дээд хэмжээ нь 2020 оны сонгуулийн зардлын дээд хэмжээнээс өссөн нь тээвэр шатахууны үнэ 73.1 хувь, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 57.1 хувиар нэмэгдсэн, радио телевиз болон цахим орчны ашиглах хэрэглээ нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

ЗӨВЛӨМЖ:

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч нарт:

1. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээг сонгуулийн хугацаанд баримтлан ажиллах.

Аудитын тайлангийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

 2024.06.24 84 ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА Танай 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/400 албан тоот болон түүний хавсралтаар ирүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Зардлын дээд хэмжээг тогтоохдоо “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийн дагуу нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа явуулах хэлбэр бүрээр мэдээлэл судалгааг бодитой хийж, үнэ ханшийн өсөлттэй уялдуулан тооцсон байна гэж үзлээ. Иймд зардлын дээд хэмжээг өөрчлөх талаар саналгүй болно. ДАРГА  ШИДЭРБАЯСГАДАН	Хөвсгөл аймгийн Ардчилсан нам нь Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээтэй санал нэг байгаа тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.
--	--



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН
АХРСС

Мөрөн сум Хөвсгөл аймгийн 00130
2024.06.20 10:54

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай 2024 оны 6 сарын 05 ны өдрийн 01/379
тоотын дагуу 2024 оны Орон нутгийн Иргэдийн
Төлөөлөгчдын хурлын сонгуулийн зардлын саналыг
хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

Хөвсгөл МАН-ын хороо

2024 оны Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын сонгуульд МАН-аас зарцуулах зардлын дээд хэмжээний санал

2024.6.19

№	Зардлын нэр	Ангилал	Зардлын дүн	Тайлбар
1	Сонгуулийн сурталчилгааны материал хангуулах, сонгогчид тархах зардал	Сонгуулийн сурталчилгааны материал хангуулах зардал Сонгуулийн сурталчилгааны материал тархах зардал	132,000,000.00 39,750,000.00	
2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны тусгай дэлгэр байрлуулах зардал		35,175,000.00	
3	Нийтийн дэлбэр гудамж, талбайд байрлуулах тавих тэмдэг үрэг зэргийн зардал		19,330,000.00	
4	Сонгогчид төр, улс төр зүгээр лүүлэн хийх зардал		71,750,000.00	
5	Сонгууль эрхэлсэн байгууллагад үзүүлэх байр ашиглуулалт-ын зардал	Үзүүлэх байрны гэрээний зардал Нам, засалзас зарцуулах хэлсэ урьшигуулах зардал Нам, засалзас зарцуулах төхөөрхөн хэргэсгийн зардал Сонгуулийн сурталчилгааны материал хангуулах зардал	22,400,000.00 478,000,000.00 84,600,000.00 40,000,000.00	
6	Сонгуулийн сурталчилгааны материал, гэрээний зардал		18,000,000.00	
7	Цэвэр орон зай зориох зардал		35,000,000.00	
8	Бусад тусламж бусад бусад санал сэтгэлд сонгуулийн сурталчилгааны материал хангуулах зардал		35,000,000.00	
	Дүн		1,097,425,000.00	

Харгалзан Дарга Л.Төмөрбаатар
Салал болж оруулсан Д.Гэрэлчулуун

Хөвсгөл аймгийн Монгол ардын намаас ирүүлсэн зардлын санал нь Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээнээс доогуур байгаа тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.